

"АБТС ББСБ" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны  
06 сарын 06-ны өдрийн хурлын 1 дүгээр тогтоолын хавсралт 1



**"АБТС ББСБ" ХХК-ИЙН  
"КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС"-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБОР  
НЭГНИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

**1.1.** Энэхүү "АБТС ББСБ" ХХК-ийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх хөтөлбөр (цаашид "Хөтөлбөр" гэх)-ийн зорилго нь компанийн дотооддоо мөрдөх бодлогын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг "Компанийн засаглалын кодекс"-ийн зарчимд нийцүүлэн баталгаажуулах, дагаж мөрдсөнөөр компанийн засаглалын зарчмуудыг үйл ажиллагаандaa нэвтрүүлж, хэвшил болгоход оршино.

**ХОЁР.ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

**2.1.** Хөтөлбөрийн зорилт:

- 2.1.1.хувьцаа эзэмшигчийн эрхийг баталгаажуулах;
- 2.1.2.төлөөлөн удирдах зөвлөл /цаашид ТУЗ гэх/ болон гүйцэтгэх удирдлагын хариуцлагын тогтолцоог олон улсын жишигт хүргэх;
- 2.1.3.тайлагнал, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах;
- 2.1.4.эрдээлийн удирдлагыг сайжруулах;
- 2.1.5.хяналтын тогтолцоог сайжруулах.

**2.2.** Хөтөлбөрийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

- 2.2.1.Компанийн тухай болон Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, "Компанийн засаглалын кодекс"-т тусгагдсан бодлогын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг компанийн засаглалын үндсэн зарчим, хэм хэмжээнд нийцүүлэн мөрдүүлэх;
- 2.2.2.компанийн бодлогын баримт бичиг, дүрэм, журам, зааврын хэрэгжилтэд комплайнсын хяналтыг тогтмол хэрэгжүүлэх;
- 2.2.3.эрх бүхий албан тушаалтан, ажилтныг компанийн засаглалын сургалтад хамруулах;
- 2.2.4.хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах, мэдээлэх.

**ГУРАВ.ХӨТӨЛЬБӨРИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

**3.1.** Энэхүү хөтөлбөрийг компанийн ТУЗ нь өөрийн байгууллагын бизнесийн цар хүрээ, үйл ажиллагааны онцлог, бүтэц, зохион байгуулалтад нийцүүлэн баталж, холбогдох бодлогын баримт бичиг, дүрэм, журам, зааврын хэрэгжилтэд хяналт тавина.

**3.2.** ТУЗ нь дараах чиглэлээр бодлогын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг баталж, мөрдөнө:

- 3.2.1. дүрэм, бодлогын баримт бичиг, заавар болон бусад:
  - 3.2.1.1. ёс зүй;
  - 3.2.1.2. залгамж халаа;
  - 3.2.1.3. цалин, урамшуулал;
  - 3.2.1.4. ногдол ашиг;

- 3.2.1.5. эрсдэлийн удирдлага;
- 3.2.1.6. дотоод аудит;
- 3.2.1.7. дотоод хяналт;
- 3.2.1.8. комплайнсын хяналт;
- 3.2.1.9. холбогдох хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, дотооддоо мөрдөх стандарт, аргачлалыг багтаасан бусад баримт бичиг.

3.2.2. дотоод журам:

- 3.2.2.1. хувьцаа эзэмшигчдийн хурлын журам;
- 3.2.2.2. ТУЗ-ийн үйл ажиллагааны журам;
- 3.2.2.3. ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үйл ажиллагааны журам;
- 3.2.2.4. ТУЗ-ийн дэргэдэх холбогдох хороодын үйл ажиллагааны журам;
- 3.2.2.5. гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журам;
- 3.2.2.6. мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам;
- 3.2.2.7. дотоод хяналт, комплайнс, дотоод аудитын нэгж, эсхүл ажилтны үйл ажиллагааны бусад шаардлагатай журам.

## ДӨРӨВ. ТАЙЛАГНАЛ, ҮНЭЛГЭЭ

- 4.1. ТУЗ нь байгууллагын дүрэм, бодлогын баримт бичиг, заавар, журам, загварыг боловсруулах, мөрдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн, явцын талаар жил бүрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тайлagnана.
- 4.2. ТУЗ нь хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан, компанийн засаглалын үнэлгээг компанийн үйл ажиллагааны тайланд тусгаж, компанийн цахим хуудсанд байршуулна.
- 4.3. ТУЗ нь жил бүрийн эхний улиралд багтааж, компанийн засаглалыг үнэлэх асуулгын дагуу ёөрийн компанийн засаглалын түвшинг үнэлж болно.
- 4.4. ТУЗ нь хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг хувьцаа эзэмшигчдийн хурлын материалын хамт Хороонд хүргүүлнэ.